


## Силикат ХК(SIL.MSE)

Салбар: Аж үйлдвэр

### Хувьцааны үнэ



### Үнэт цаасны үзүүлэлтүүд

Симбол	SIL
Хувьцааны код	317
Нийт гаргасан хувьцаа (2012 он)	46,334,602
Зах зээлийн үнэ 2012.11.26 (төгрөг)	185
Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	8.57
52 долоо хоног- их/бага (төгрөг)	233 / 175

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	5.18	9.18
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	0.04	0.01
Биет бус хөрөнгө ба өр төлбөр (тэрбум төгрөг)	2.25	5.24
Эзэмшигчийн өмчийн дүн (тэрбум төгрөг)	3.02	4.02
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	0.85	0.24
Үнэ ашгийн харьцаа (P/E)	441.73	1,000.4
Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B)	5.91	2.87
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.8%	0.1%
Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE)	1.3%	0.3%
Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)	-	-
Ногдол ашгийн өгөөж	-	-
Дундаж хувьцааны үнэ (төгрөг)	373.69	243.27
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	17.31	11.27
Дансны үнэ (төгрөг)	63.22	84.85
Үнийн хэлбэлзэл	3.35%	15.8%

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Судалгааг бичсэн:

### Цэдэвдорж ЧИМГЭЭ,

Судалгааны багийн ахлагч

[chimgee@standardinvestment.mn](mailto:chimgee@standardinvestment.mn)

T +976 701 14433

M +976 99066293

### Бямба МӨНХТУЯА,

Судалгааны ажилтан

[munkhtuya@standardinvestment.mn](mailto:munkhtuya@standardinvestment.mn)

T +976 701 14433

M +976 99027432

## КОМПАНИЙН ТОЙМ

### Танилцуулга

Силикат ХК нь анх 1966 онд БНПАУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар Дархан хотод шохой ба цагаан тоосгоны үйлдвэр нэртэйгээр анх ашиглалтанд орсон. 1992 онд хувьчлагдаж ХК болжээ. 1992-2005 оны хооронд үйл ажиллагаа доголдон үйлдвэрлэл зогссон авч 2006 оноос хөрөнгө оруулалт хийгдэн үйл ажиллагаа жигдэрч эхэлсэн байна. Тус компани нь барилгын материал болох хөнгөн бетон блокны үйлдвэрлэл, шохойн үйлдвэрлэл, элс болон шохойн чулуун олборлолтыг хийж байна. Дархан-Уул аймгийн Хонгор сумын Цогт хэмээх газарт 24.9 га (1.2 сая тонн шохойн чулуун нөөцтэй) талбайд ашиглалтын лицейнзтэй, Сэлэнгэ аймгийн Сайхан суманд 31 га талбайд хайгуул хийх тусгай зөвшөөрөлтэй газар эзэмшиж байна.

### Менежмент

Силикат ХК нь 2012 оны 3дугаар улирлын байдлаар нийт 46,334,602 хувьцаа гаргасан бөгөөд одоо байгаа удирдлагын баг нь 2004 онд хяналтын багцыг авсан байна.

Хувьцаа эзэмшигчид	Бүтэц
Ц.Содбилэг	Силикат ХК-ийн гүйцэтгэх захирал 16%
С.Золбоотөгс	Сурагч 14%
С.Оджаргал	Сурагч 12%
Д.Энхболд	Силикат ХК-ийн санхүү эрхэлсэн захирал 8%
В.Мөнхтуяа	Агч Трейд ХХК нягтлан бодогч 8%
Н.Цогцлон	Силикат ХК-ийн бодлого төлөвлөлт хүний нөөц хариуцсан захирал 5%
Бусад (237 хувьцаа эзэмшигч)	37%

Эх сурвалж: УЦТТХТ

### ТУЗ-ын дарга Д.Туул

Даваасүрэнгийн Туул нь хуульч эрх зүйч мэргэжилтэй. 2005 оноос хойш ТУЗ-ын даргаар ажиллаж байна.

### Гүйцэтгэх захирал Ц.Содбилэг

Ноён Цэрэннадмидийн Содбилэг нь 1968 онд Өвөрхангай аймагт төрсөн. 1993-1997 онд социологи ба философийн мэргэжлээр суралцаж төгссөн. 1998-2007 онд Монгол газар ХХК-д захирлаар ажилласан ба 2007 оноос хойш Силикат ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

### Үйлдвэрлэл эрхэлсэн захирал Ц.Сэргэлэн

Ноён Цэрэннадмидийн Сэргэлэн нь 1960 онд төрсөн. 1981 онд Дархан хотын Политехникум, 1995 онд Техникийн дээд сургууль төгсч уулын баяжуулах мэргэжлийг эзэмшсэн. 2005 оноос хойш Силикат ХК-д ажиллаж байна. 2008 онд ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байжээ.

**Зах зээлийн мэдээлэл**



Эх сурвалж: МУ Статистикийн хороо

Монгол Улсын хэмжээнд барилгын болон уул уурхайн салбар 2008, 2009 оноос эхлэн өргөжин тэлж хөнгөн бетон болон шохойн эрэлт хэрэгцээ ихсэж шохойн 1 кг-ийн үнэ 2008 онд 500 төгрөг байсан бол 2011 онд 600 төгрөг болж өсчээ. Хөнгөн бетоны үнэ 700м³ нь 2008 онд 83,000 төг байсан бол 25 хувиар өсч 106,667 төгрөг болжээ. МУ-ын хэмжээнд шохойн нийт үйлдвэрлэлийн 10-21 хувийг Силикат ХК 2008-2010 оны хооронд үйлдвэрлэж байжээ.

**Компанийн өсөлт, хөгжил**

Силикат ХК нь 1966 онд Дархан хотод шохой ба цагаан тоосгоны үйлдвэр нэртэйгээр анх ашиглалтанд орохдоо жилд 22 мян.тонн шохой, 29 сая ширхэг тоосго, хоногт 60-70 тонн 60-70 хувийн идэвхжилтэй шохой, 100-120 мян.ширхэг 100-150 маркийн силикат тоосго үйлдвэрлэж МУ-ын ханын материалын хэрэгцээний 25 хувийг хангаж МҮ-руу экспортолж байжээ.

1992 онд хувьчлагдснаас хойш үйлдвэрлэлийн техник технологийн шинэчлэл, хүчин чадал сайжруулах шаардлага гарсан авч хөрөнгө оруулалт хийгдээгүй ба 1998 онд эдийн засгийн хямрал болон нийгмийн системийн өөрчлөлтийн нөлөөллөөр үйлдвэрлэл зогссон байна. 2004 он хүртэл барилгын салбар зогсонги байдалд орсноор тоосгоны эрэлт буурч түүнчлэн үйлдвэрийн бүх шатны тоног төхөөрөмж хуучирч ажиллагаагүй болсон үйлдвэрийг одоо байгаа удирдлагын баг хяналтын багцыг худалдаж авч, 2005 онд компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчилсэнээр үйлдвэрийг сэргээн ажиллуулах болжээ. 2006 онд 460 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг хийж үйлдвэрлэлийг эхлүүлжээ. Зах зээлийн эрэлт хэрэгцээгээр цагаан тоосгоны үйлдвэрлэх техник тоног төхөөрөмжийг байршуулах, шохойн үйлдвэрлэлийн төслүүд боловсруулан тухайн үеийн Зоос банктэй хөрөнгө оруулалтын гэрээг байгуулан 2007-2008 онд 2 тэрбум төгрөг зээлэн төслүүдийг хэрэгжүүлж эхэлжээ. 2008-2009 онд эдийн засгийн хямрал болон Зоос банкны үйл ажиллагаа доголдон зээлээр бүрэн хангаагүйгээс төсөл бүрэн хэрэгжээгүй ба борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Барилгын салбарын хямралаас шалтгаалан хөнгөн бетоны үйлдвэрлэл багассан авч уул уурхайн салбар өсөн хөгжиж шохой эрэлт хэрэгцээ нэмэгдэн өргөтгөж амжаагүй байсан үйлдвэрлэлийн хүчин чадалаа өргөтгөхийн тулд нэмэлт хувьцаа гаргажээ.

Силикат ХК нь анх 170,126 ширхэг хувьцаатай байсан ба 2004 онд эдгээр хувьцааны 98 хувь нь төвлөрсөн байсныг 2011 онд нэг ширхэг хувьцааг 177 ширхэгт хуваан нийт 30,112,302 хувьцаатай болжээ. Мөн 2011 онд өмнөх хувьцааны 35 хувь болох нэмэлт 16,222,300 ширхэг хувьцаа гарган нийт 46,334,602 хувьцаатай болсон байна. Нэмэлт хувьцааны нэрлэсэн үнийг 225 төгрөгөөр тогтоосноор нийт 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг босгожээ.

Силикат ХК-ийн 2011 оны сүүлийн байдлаар үйлдвэрлэлийн хүчин чадал: хөнгөн бетон жилд 40,000 м³, шохой жилд 10,000 тонн, шохойн чулуу цагт 40 тонн олборлох хүчин чадалтай юм. Олборлосон шохойг 60-93 мм ширхэгтэйг өөрийн хөнгөн бетоны үйлдвэрлэлд түүхий эд болгон ашиглахаас гадна хэрэглэгдэхгүй 15-45 мм ширхэгтэйг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт, 5-15 мм ширхэгтэйг барилгын компаниудад дайрганы зориулалтаар,

0-25 мм-тэйг Эрэл цементийн үйлдвэрт борлуулдаг. Мөн зуухнаас гарсан нунтаг шохойг Бороо гоулд болон Арьс ширний үйлдвэрт нийлүүлдэг байна. Силикат ХК нь 2008-2010 онд үйлдвэрлэлийн хүчин чадлыг барилгын салбараас илүү уул уурхайн салбарын түүхий эд болох шохой үйлдвэрлэхэд ашигласныг доорх хүснэгтээс харж болно.

Бүтээгдэхүүн	2008	2009	2010
Хөнгөн бетон, мян.м³	19.9	9.7	10
Шохой, мян.тонн	5.3	9.1	7.2

Эх сурвалж: Силикат ХК

Силикат ХК нь Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт байрладаг ба дэд бүтцээр бүрэн бие даасан. Мөн ойрын хугацаанд үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулах дэд бүтцийн нэмэгдэл эх үүсвэр шаардлагагүй хэмээн удирдлага тэмдэглэжээ.

**Дүгнэлт**

2011 онд Силикат ХК-ийн борлуулалтын орлого нь 1.95 тэрбум төгрөг, борлуулалтын өртөг нь 1.71 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлын дүн 238 тэрбум төгрөг байж, 2011 онд нийт 11.3 сая төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна.

Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B) 2010-2011 онд 5.91-ээс 2.87 болж буурсан нь хувьцааны үнэлгээ 2010 онд харьцангуй өндөрөөр үнэлэгдсэнийг харуулж байна. Үнэ ашгийн харьцаа (P/E) 2010-2011 онд 441.73-аас 1,000.4 болж өссөн нь 2010 онд SIL хувьцааны үнэ харьцангуй өндөр үнэлэгдснийг бататгаж байна. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 2010 онд 0.8%, 2011 онд 0.1%, эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE) нь 2010 онд 1.3%, 2011 онд 0.3% байсан нь 2011 онд 2010 онтой харьцуулахад ROE ба ROA багассан нь менежмент сайн байгаагүйг илтгэж байж болно. 2012 оны эхээс өнөөдрийг хүртэл хувьцааны үнэ 2.64 хувийн хэлбэлзэлтэй байгаа нь өмнөх 2010, 2011 онынхоос бага хэлбэлзжээ. Силикат ХК нь одоогийн шохой үйлдвэрлэлтээрээ 100 жилийн нөөцтэй юм. Силикат ХК нь Монгол Улсад хөгжиж буй уул уурхайн салбар ба барилгын салбарт хэрэглэгддэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг тул энэхүү хоёр салбарын хөгжлийн явцаас тухайн үйлдвэрийн үйл ажиллагаа хамаардаг байна. Тиймээс барилгын болон уул уурхайн баяжуулах салбаруудын хөгжил улам сайжирснаар мөн тухайн компанийн менежмент сайн байж орлогоо сайжааруулснаар SIL хувьцааны үнэ нэмэгдэх болно. Силикат ХК нь 1994 онд 6 төгрөгний ногдол ашиг олгож байснаас хойш дахин олгоогүй байна.

## Холбоо барих

### Хаяг:

Стандарт Инвестмент ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо  
Жигжиджавын гудамж 5/3

### Шуудангийн хайрцаг:

Төв шуудан, Улаанбаатар 15160,  
Хайрцагны дугаар 1487

Утас: +976 7011 4433

Факс: +976 7011 4433

[www.standardinvestment.mninfo@standardinvestment.mn](mailto:www.standardinvestment.mninfo@standardinvestment.mn)

## Мэдэгдэл

Энэхүү судалгааг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд бүх мэдээллийг найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Гиймээс Стандарт Инвестмент ХХК нь эдгээр мэдээллийг үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн энэхүү мэдээллийг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт Инвестмент ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү мэдээлэл нь ямар нэгэн үнэт цаасны худалдан авах, худалдах санал буюу хөрөнгө оруулалтын зөвөлгөө биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно. /Стандарт Инвестмент ХХК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Мэдээллийг зөвхөн хаягласан хувь хүн болон албан байгууллагын хэрэглээнд зориулсан ба Стандарт Инвестмент ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр цааш нь дамжуулах, түгээх, хуулбарлахыг хариглоно.

© 2012 Standard Investment LLC